



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ӨНДӨРШИЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 113

Бөхт

Үндсэн хөрөнгө бүртгэлээс хасч үнэ тогтоон  
худалдах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн 35.1.11 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.5, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 6.2 дахь хэсгийн 6.2.5, 6.4 дэх хэсгийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2019 онд үйлдвэрлэгдсэн, 2,000,000 төгрөгийн балансын өртөгтэй, 1,200,000.08 төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Ямасаки маркийн мотоциклийг данснаас хасч 50,000.00 (тавин мянган) төгрөгөөр худалдахыг зөвшөөрсүгэй.

2.Үнэ тогтоон худалдах хөрөнгийн мэдээллийг хавсралтаар баталсугай.

3.Тогтоолын хэрэгжилтийн тайланг 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд ирүүлэхийг Сумын Засаг дарга (У.Алтанхүү)-д даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Д.Уранбилэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.МӨНХЦЭЦЭГ

432301064

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 113 дугаар тогтоолын хавсралт

ҮНДСЭН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСЧ ҮНЭ ТОГТООН ХУДАЛДАХ  
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Огноо	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ	Худалдах үнэ
1	Мотоцикль	2019	ш	1	2,000,000	2,000,000	50,000
НИЙТ ДҮН				1	2,000,000	2,000,000	50,000